



## “АЛЛАГА, АУГАА ЯЛЛАЛТ БА ХУРИМЫН НАЙР”

СБС-ийн Хиймэл Дагуулын Шууд Нэвтрүүлэг—2004 оны Есдүгээр сарын 12

### Ахлагч Жеффри Р. Холланд

Энд хүрэлцэн ирсэн та бүгдэд баярлалаа, та нарын дунд үг хэлэгчийг танихгүй хүн байж магадгүй, та нартай хамт өнөө орой энд байгаа нь миний хувьд сэтгэл хөдөлгөм үйл явдал болж байна. Та бүгд хаанаас ирсэн бэ? (Үүнд хариулах хэрэггүй, бидэнд цаг алга.) Хэдийгээр би та нарыг бүгдийг нь харж чадахгүй ч гэсэн, дэлхий даяар бусад олон газарт та нараас илүү олон хүн нийтдээ 80,000 орчим хүн цуглаад байгаа, хиймэл дагуулын энэхүү гайхамшигт үзэгчдийг би оюун санаандаа нэн сайн төсөөлж байна. Энд хүрэлцэн ирсний тань төлөө бид та нарт баяр хүргэе, мөн намайг үг хэлэхийг урьсан та бүгдэд баярлалаа.

Холланд Эгчийн өмнөөс би хүлцэл өчихийг хүсч байна. Тэр өнөө орой энд бидэнтэй хамт байсан бол түүнд ихэд таалагдах байсан биз ээ, гэвч тэр одоо Техасын Хьюстонд, манай охин, хүргэн хоёрын бүлд шинээр ам нэмсэн ач охиндоо тусалж байгаа билээ. Хэрэв Хьюстонд цугласан хүмүүс танхимын ар тал уруу алгуурхан эргэж харвал, арын эгнээнд сууж, институтын сонсогч байхыг хүссэн бололтой, жижигхэн биетэй эмээг харах байх. Ах нараа, тэр хичнээн залуухан харагдахыг би бүрнээ ухаарч байна, гэвч түүнтэй болзоо тавих гэсний хэрэггүй. Тэр чинь аль хэдийн нөхөрт гарчихсан юм. Тэр өнөө орой энд миний дэргэд байсан бол надад хичнээн их дэмжлэг болох байсны адилаар, мөн тэнд тийм л байгаа гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Би та нарт түүний хайрыг авчирлаа, зөвхөн ийм үед эмэг эхийн үүрэг ямар байх нь түүнийг өнөө орой энд бидэнтэй хамт байхаас хөндийрүүлсэн биз ээ. “Хермана Холланд, те амо”.

Холланд Эгч бид хоёр Чили дэх хоёр жилийн томилолтоосоо дөнгөж саяхан буцаж ирээд байгааг та нараас олон нь мэдэж байгаа, тэнд ч олон хүн өнөө орой та нарын нэгэн адил цуглаад байгаа, тэнд бид хоёр Сүмийн төв байгууллагуудаас алс хол, дэлхийн талаас хол газар эдгээр шууд нэвтрүүлгүүдийг хүлээн авч, залуу насанд хүрэгчид болон институтын суралцагчидтай хамт суудаг байлаа. Бид ч бас Их Эзэний Сүнсний түүнчлэн удирдагчдаа хайрлах хайрыг мэдэрдэг байлаа. Бид дэлхий даяарх өөрсдийн насны, бидэнтэй итгэл нэгтэй, та нарын нэгэн адил бүрэн дүүрэн аз жаргалтай ирээдүйн төлөө нэг адил

зүйлүүдийг хүсдэг мянга, мянган хүмүүстэй үерхэх нөхөрлөлийг бүр ч ихээр мэдэрдэг байлаа.

Би өнөө орой Чили дэх залуу найз нар аа, нэн их, гэхдээ дэлхий даяарх—Англи, Франц, Солонгос, Япон, Австрали, Нигери болон Украин дахь бүх найз нартайгаа, мөн түүнчлэн Хойд Америк даяар ийм олуулаа цуглаад байгаа та нарыг оролцуулан бүгдийг адил хэмжээгээр санаж байна. Та нар ямар ч хэлээр ярьдаг нь, ялгаагүй, би та нарт хайртайгаа илэрхийлж, “Биенвенидос” хэмээн чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье. Бидний тоонд асар их хүч чадал бий. Бид бүгдийн дээр Их Эзэний Сүнс болон адислалууд байхын төлөө би залбирч, миний хэлэх зүйл та нарын хүн бүгдэд ямар нэг хэмжээгээр үнэ цэнэтэй байхыг чин сэтгэлээсээ хүсч байна.

### Аллага

Дэлхий дэх өнөөгийн айдас түгшүүрийн тухай, түүнчлэн эх оронд маань болон хилийн чанадад бидэнд учирч байгаа бэрхшээлүүдийн талаар би өнөө орой та нарт ярихыг хүсч байна. Эрин зуун болон эрин үе болгонд бэрхшээлүүд байсан нь мэдээж боловч өчигдөр—9-р сарын 11—бүх дэлхийг доргиосон тэрхүү харгис хэрцгий, бараг төсөөлөмгүй үйл явдлын гурван жилийн ой байлаа. Тэрхүү үйл явдлын хор уршиг дэлхийн амьдарч ирсэн арга замуудыг хүчээр өөрчлөхөд олон талаар нөлөөллөө. Өчигдөр ийм ой болсноор айдас хүйдэс хийгээд манай өнөө үетэй холбогдсон сэтгэлийн түгшүүрүүд бидний зүрх сэтгэлд өнөөдөр ч хэвээр байж болох юм.

Ямар ч тохиолдолд өнөө орой бид энэ шууд нэвтрүүлгийг хүргэж байгаа бидний хөршүүд—улс орны иргэд, тэрчлэн бусад улс үндэстнүүд 2001 оны 9-р сарын 11-нээс хойш айдас түгшүүрийн байдалд байж, түүнчлэн олон улсын үйл явдлуудад сэтгэл түгших нь улам ч ихэсч, “аллага” гэдэг шинэ үгийг бүх нийтээрээ бараг л ердийн үг мэт хэрэглэдэг болжээ. Хэдхэн жилийн өмнө энэ үгийг бараг л бүхэлд нь хоёрдугаар зэрэглэлийн киноны зар сурталчилгаанд болон зөвхөн аймшгийн зохиолуудад л ашигладаг байлаа. Гэтэл одоо, энэ нь манай сонинууд, тэрч байтугай бага насны хүүхдүүд түүний

дотор Орос дахь сургуулийн хүүхдүүдийн ярианд өдөр тутмын хэрэглэдэг үг хэллэг болсон нь нэн харамсалтай юм, бидний амьдардаг дэлхий “алан хядагчид” гэж нэрлэгддэг хүмүүст харгис хэрцгийгээр, цус урсгалтаар нэрвэгдэж болохыг хүүхдүүдэд хүртэл ой тойнд нь ортол ойлгууллаа. Түүнчлэн байгалийн болон бусад төрлийн гамшгууд гарсаар байгааг, сонин хэвлэлүүдэд баримтжуулагдсан эдгээр гамшгууд нь амьдрал эмзэг хэврэг болж, энэхүү амьдрал үйл явдлуудын үйлийн үрт хувь тавиланд өртөж болохыг бидэнд сануулсаар байна.

### Эцсийн өдрүүд

Ийм нөхцөл байдалд та нараас олон хүн, энэ бүхэн чинь дэлхийн төгсгөлийг түүнчлэн дэлхий дээрх та нарын амьдралын төгсгөлийг ёрлоод байгаа юм биш үү гэж зүрх сэтгэлдээ түгшүүрлэн бодож байгааг би мэдэж байна. “Энэ чинь Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн цаг, түүнчлэн энэ бүхэн чинь энэ үйл явдлын эргэн тойронд болох зүйлийг бошиглосон тэр зүйл мөн үү?” гэж хүн асууж байна. Үнэхээр, 9-р сарын 11- ний дараа их удалгүй нэг номлогч надаас, бүхий л чин сэтгэлээсээ, бүрэн дүүрэн итгэлтэйгээр “Ахлагч Холланд аа, энэ чинь сүүлчийн өдрүүд мөн үү?” гэж асуусан юм. Чин үнэнээсээ асууж байгааг нь мөн нүдэнд нь нулимс цийлэлзэхийг би харсан бөгөөд түүнийг тайвшруулахыг хичээж билээ. Би түүний айдас түгшүүрийг багахан ч болов хөнгөвчлөхийн тулд түүнийг нэг гараараа тэвэрч, нэг хошигнол бодож олов. Би түүнийг чанга тэврээд, “Ахлагч аа, би хамгийн ухаалаг, хөгжилтэй хүн биш л дээ, гэвч би Сүмийн нэрийг мэддэг юм шүү дээ” гэж хэлж билээ. Тэгээд бид “Хожмын үеийн” Гэгээнтнүүд байх тухай ярилцсан юм. “Тийм ээ, Ахлагч аа, бид сүүлчийн өдрүүдэд байгаа, гэвч эдгээр нь цоо шинэ юм огт биш. Аврагчийн амласан Хоёр дахь Ирэлт 1820 онд Бошиглогч Иосеф Смитийн Анхны Үзэгдлээр эхэлсэн юм. Тэгэхлээр Хоёр дахь Ирэлт болон сүүлчийн өдрүүд нээгдсэнийг үзсэн бидний туршлага аль хэдийн 184 жил орчим болоод байна шүү дээ. Бид сүүлчийн өдрүүдэд—үүний олон олон он жилүүдэд— бид амьдарч байгаа нь тодорхой байна гэж би боддог доо” гэж би түүнд хэлээд түүнтэй нөхөрсгөөр гар барьж тэгээд түүнийг замаар нь явуулж билээ.

Тэр инээмсэглэж, тэр энэ бүх бодлоо орхин, нилээд тайвширсан бололтой, өөрийнхөө замаар яваад өгөв. Тэр номлолоо амжилттай дуусгаад удаж байгаа, одоо гэртээ гэргийтэйгээ хамт баяр хөөртэй байгаа байх, магадгүй энд хаа нэгтээ сонсогчдын дунд эхнэр

болгох хүнээ хайгаад сууж байж ч магад гэдэгт би итгэлтэй байна! (Түүнд амжилт ерөөе.)

Энэ залуу хүний үнэнхүү чин сэтгэлээсээ асуусан тэр зүйлийг би мэднэ гэж хэлэхийг би урьтал болгон хэлмээр байна. Түүний асуусан зүйл нь чухамдаа: “Би номлолоо дуусгах болов уу? Боловсролтой болох боломж бий болов уу? Гэрлэх найдлага надад байна уу? Надад ирээдүй байгаа болов уу? Цаашид надад аз жаргал байх уу?” гэж асуусан хэрэг байлаа. Гурван жилийн өмнө би түүнд хэлснээ одоо би та бүгдэд хэлье. “Бүх асуултуудад—Тийм ээ, тэгэлгүй яахав гэж хариулъя.”

Хоёр дахь Ирэлтийг дэлхийг донсолгосон үйл явдлуудын хамт, эцсийн жинхэнэ хугацааг нь нийтэд мэдүүлэх тухайд гэвэл, энэ нь хэзээ тохиохыг би мэдэхгүй. Бас энэ нь хэзээ тохиохыг Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли ч мэдэхгүй гэдгээ тэр хэлсэн, учир нь гэвэл Хоёр дахь Ирэлт хэзээ тохиохыг хэн ч мэдэхгүй. Тэр ч байтугай тэнгэр дэх тэнгэр элчүүд ч үүнийг мэдэхгүй гэж Аврагч хэлсэн билээ (Матай 24:36).

Бид тэмдгүүдийг харж, цаг хугацааны утга учрыг уншин тайлж байх ёстой, бид чадах чинээгээрээ итгэлтэйгээр амьдрах ёстой, түүнчлэн адислалууд хийгээд хамгаалалт хүн бүгдэд хүртээмжтэй байхын тулд бид уулзсан хүн бүртэй сайн мэдээг хуваалцах хэрэгтэй. Гэвч ирээдүйд ямар нэг мэдэгдэхгүй цаг тохиох нь гэдгээс, мөн уг үйл явдал болон үүний эргэн тойрон дахь үйл явдлуудаас ухаан алдталаа айх хэрэггүй, бас тэгэх ёсгүй. Бид амьдралыг зогсоож чадахгүй. Харин ч бид урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр тийм бүрэн дүүрэн амьдралаар амьдрах ёстой. Эцсийн эцэст энэ бол цаг хугацааны бүрэн дүүрэн байдлын эрин үе юм.

9-р сарын 11-ний үйл явдлаас хойш саяхныг хүртэл нөгөөх номлогчийн дотроо бодож явсан асуултуудын талаар та нарын насныхны бүлэг дотор нэн их айдас түгшүүртэй, тэр ч байтугай гутрангүй санаа бодол байдаг гэж би боддог, мөн энэ тухай би сонссон. Та нарын зарим нь, хэрэв бидний амьдарч байгаа дэлхийн улс төрийн болон эдийн засгийн байдал цаашид ийм тодорхойгүй байх юм бол номлолд явах юм уу эсвэл боловсрол олж авах болон ирээдүйгээ төлөвлөхөд зорилго тавих шаардлага байна уу гэж эргэлздэг тухай би сонссон. Тэр ч байтугай, “Ийм тодорхой биш цаг үед бид гэрлэх хэрэгтэй юү гэдгээ мэдэхгүй байна” гэж хайр сэтгэлтэй хүмүүс хэлдэг тухай би сонссон.

Айдсаар дүүрэн дэлхийд хожмын өдрүүдийн сүйрлийн гай гамшиг дунд хүүхэд төрүүлэх хэрэг байна уу гэж эргэлздэг шинээр гэрлэсэн зарим хосууд байдаг гэж би сонссон нь энэ бүхнээс хамгийн адгийнх нь юм. Юутай ч гэсэн, ийм үг яриа миний сэтгэлийг Аль-Каидагаас илүү зовоодгийг би та бүгдэд хэлмээр байна.

Ирээдүйн тухайд ээдрээтэй байгаа та нарын дунда хэнд ч болов хандаж хэлэх хоёрхон зүйл надад байна. Би үүнийг хайраар, зүрх сэтгэлээсээ хэлж байна.

Нэгдүгээрт, ямар ч үед, ямар ч нөхцөл байдалд, хэзээ ч итгэл хийгээд итгэлтэй амьдралаас маань биднийг гаргах боломжийг айдас болон айдсын эцэгт (Сатанд) олгохгүй байцгаая. Ирээдүйн тухай асуултууд ямагт гардаг л даа. Эрин үе болгонд залуу хүн бүр эсвээс гэр бүлийн залуу хос бүр—Адам, Ева хоёр Едений Цэцэрлэгээс гарч үл мэдэгдэх алхмуудыг хийснээс эхлэн тодорхой биш зүйл үргэлж байсаар ирсэн амьдралд итгэлтэйгээр алхлах шаардлага гарсаар ирсэн билээ. Гэвч энэ нь байдаг л зүйл юм. Энэ нь сайн байх болно. Энэ бол төлөвлөгөө. Төлөвлөгөө ч сайн байх болно. Зөвхөн итгэлтэй бай. Бурхан үүнийг хариуцдаг. Тэр та нарын нэрийг мэддэг бас Тэр та нарын хэрэгцээг мэддэг.

Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл бол—сайн мэдээний анхдагч зарчим юм. Өнгөрсөн үеийн манай анхдагчуудын дурсгалд зориулсан К. Невелл Дейлигийн дуулалд “алхам бүрдээ итгэх итгэл”<sup>1</sup>—харин анхдагчууд шиг л хэмээн өгүүлдэгчлэн—бид урагшаа явах ёстой—та бүгд итгэлийн ийм алхаагаар—нэг алхаад дараа нь нэг алхам хийж, тэгээд дараагийнхыг нь гэхчлэнгээр алхах ёстой. Энэ нь зорилтууд хэрхэн хэрэгждэг хийгээд зорилгууд хэрхэн биелэгддэг хийгээд фронтын шугамуудыг хэрхэн байлдан эзэлдгийг харуулдаг юм. Илүү бурханлиг хэлээр бол энэ нь дэлхийнүүд хэрхэн бүтээгддэг хийгээд та нарын дотоод ертөнц хэрхэн бий болдог тэр зүйл юм.

Хангалттай итгэл хийгээд шийдвэр төгс байдал, Түүнд итгэх хангалттай итгэлийг, урагш ахиж байхыг, амьдралаа авч явахыг, баяр хөөртэй байхыг Бурхан та нараас хүсэн хүлээдэг. Чухамдаа бол Тэрээр ирээдүйтэй зүгээр тулгарахыг (энэ нь нилээд хатуу чанд юм шиг сонсогдож мэднэ) та нараас хүсэн хүлээдэггүй. Ирээдүйг угтан авч түүний төрхийг бий болгон үүнийг хайрлаж, үүнд баясан, мөн өөрсдөд тань ирэх боломжуудад баярлахыг Тэрээр та нараас хүсэн хүлээдэг билээ.

Бурхан та нарын залбирлуудад хариулах, түүнчлэн та нарын мөрөөдлүүдийг гүйцэлдүүлэх боломжид Тэрээр цаг үргэлж санаа тавин, бас үүнийг хүсэн хүлээж байдаг. Гэвч хэрэв та нар залбирахгүй бол Тэр хариулж чадахгүй, мөн хэрэв та нар мөрөөдөхгүй бол Тэр үүнийг хэрэгжүүлж чадахгүй. Товчоор өгүүлбэл, хэрэв та нар итгэхгүй бол Тэр чадахгүй.

Хүүхдийн үлгэр ярих миний өргөн мэдлэгт тулгуурлан, та нар дэлхийг үзэх аль үзлийг сонгохоо шийдэж болно. Толгой дээр нь борооны дусал унахад “Тэнгэр унаж байна, тэнгэр унаж байна” гэж бусдад хэлэн хашгирч, тэвдэн харайлгасан “Бяцхан Дэгдээхий”-тэй адилхан байх уу, эсвэл бусад амьтад түүнд туслахыг татгалзсан үед амьдралын бүтээлч зорилготойгоор талх хийхээр явдаг “Бяцхан Улаан Эм Тахиа”-тай адилхан байх уу гэдгийн аль нэгийг сонгож болно гэдгийг би та нарт хэлье.

Энэ бол фермийн тухай түүх л дээ! Одоо, амь өрсөн аюултай цаг үед амьдарч байгаа хүмүүст хандсан хоёр судар авч үзэх үү?

Нэг дэх нь Сургаал ба Гэрээний 101 дүгээр хэсэг. Хэрэв та нар санаж байгаа бол, энэ илчлэлт Миссурид цугласан Гэгээнтнүүдийг—мөрдөн хавчих нь дээд цэгтээ хүрээд байсан тэр үед ирсэн юм. Тэднийг мөрдөн хавчиж байсан нь дээд цэгтээ хүрээд байсан тэр үед. Танхайрагчид тэднийг гэр орноос нь хөөж байлаа. Тэднийг нэг гүнлэгээс нөгөө гүнлэгт хоргодох байр эрж явахад нь дайсагнал, тэр ч байтугай үзэн ядалт тэднийг салахгүй дагаж байлаа. Айдаст автсан эдгээр Гэгээнтнүүд газар, мал, хувцас хунар, гэрийн тавилга, үр тариа хийгээд их хэмжээний хувийн эд хогшлоо алдсан юм. Үхлийн аюул заналхийлэл өдөр бүр сонсогдож байлаа. Тэр үеийн хамгийн хүнд хэцүү, аюултай үе нь энэ байсан гэж би боддог—гэхдээ “аллагаар дүүрэн” гэж миний хэлэхийг—Сүм хэзээ ч мэдэхгүй. “Хооны Тээрэм” буюу “Либертийн Шорон” гэсэн нэрс бидний үгсийн санд хожуу үеийг хүртэл байсаар байх болно.

Тэрхүү аймшгийн цагт Их Эзэн Өөрийн хүмүүст хандан:

“Сионы тухайд зүрх сэтгэл чинь тайтгараг: учир нь бүх махан бодь миний мутарт байна; хөдөлгөөнгүй байж мөн би бол Бурхан гэдгийг мэдэгтүн.

“Хүүхдүүд нь тараагдсан хэдий ч, Сион байрнаасаа хөдөлгөгдөх нь үгүй.

“Үлдэх тэд, мөн зүрх сэтгэлдээ ариун тэд эргэж ирэх болно, мөн тэд хийгээд тэдний хүүхдүүд үүрдийн баяслын дуунуудтайгаар өөрсдийн өвд мөн Сионы

балгас болсон газруудыг сэргээн босгохоор ирэх бөлгөө—

“Бошиглогчдын хэлсэн эдгээр бүх зүйл гүйцэлдэхийн тулд болой” (С ба Г 101:16–19).

Иймээс залуу найз нар минь, Сионы тухайд зүрх сэтгэл чинь тайтгараг. Бидэнд өгөгдсөн Сионы хамгийн үндсэн тулгуур тодорхойлолт бол: “зүрх сэтгэлдээ цэвэр ариун” (С ба Г 97:21) хүмүүс гэдгийг санагтун. Хэрэв та нар зүрх сэтгэлээ цэвэр ариун байлгах юм бол та нарыг Сионыг байгуулах үед та нар мөн та нарын хүүхдүүд үүрдийн баяр баяслын дуунуудыг дуулах болно—мөн та нар байрнаасаа хөдөлгөгдөх нь үгүй.

Миний иш татах өөр нэг шүлэг бол Аврагч цовдлолттой тулгарч, тэгээд тэд айдас, эмх замбараагүй байдал хийгээд мөрдлөг хавчлагатай тулгарсан үед Аврагч Өөрийн шавь нарт хандан хэлсэн үг юм. Зовлонг цаг үеийн тухай яриа. Мөнх бус байдал дахь Түүний сүүлчийн хамтын зөвлөгөөнд Түүний хувьд бас шавь нарынх нь хувьд ирээдүй ямраар эргэхийг бүрэн дүүрэн мэдэж Тэрээр хэлэхдээ: “Миний дотор та нарыг амар амгалан байг гэж Би та нарт эдгээр зүйлсийг хэллээ. Дэлхийд та нар зовлонтой байх болно: гэвч зоригтой байгтун; би дэлхийг ялсан” гэжээ (Иохан 16:33).

Иймээс, зовлонгийн дэлхийд—энд зовлон ямагт мундахгүй их байх болно,—итгэлээ санацгаая. Бидэнд өгөгдсөн бусад амлалтууд, итгэл төрүүлэгч тэр бүгдийг эргэн санацгаая, мөн илүү бүрэн дүүрэн амьдралаар, манай түүхэн дэх бусад аль ч цаг үеэс илүү зоригтой, илүү овсгоо самбаатай амьдарцгаая.

Христ дэлхийг ялж, зэлүүд талд бидэнд зориулан шулуун зам зассан юм. Тэрбээр манай үед бидэнд хандан, “Хормойгоо шууж, бэлтгэгдсэн байгтун. Болгоогтун, хаант улс та нарынх болой, мөн дайсан дийлэх нь үгүй” (С ба Г 38:9) гэж хэлжээ. Тэгэхээр хормойгоо шууцгаая. Үүрдийн баяр баяслын эдгээр дуунуудыг бардам дуулцгаая.

### Агуу Ялалт

Энэ нь та бидний амьдарч байгаа цаг үед миний хийхийг хүссэн өөр нэг холбоотой үзэл баримтлал уруу хөтөлдөг.

Айдас түгшүүрийн цагт бид энэ нэрний “Хожмын үеийн” гэдэг хэсэгт (миний залуу номлогч найз шиг) их анхаарал төвлөрүүлэх шаардлагатай юм.

Гэвч энэ холбоо үгийн “Гэгээнтэн” гэдэг нэр дээр анхаарал төвлөрүүлэхийг өнөө орой би хүн бүрт

уриалж байна. Энэ бол бидний анхаарлыг шаардах, манай Сүмийн амьдралын сүнслэг хэсэг юм. Бидний эдэлдэг адислалуудын тухай бодоод үз. Бидний амьдарч байгаа гайхамшигт эрин зууны тухай бодоод үз. Дэлхийн түүхэн дэх өөр ямар ч эрин зуун буюу хүмүүс хэзээ ч үзээгүй тийм эдийн засаг, боловсрол, шинжлэх ухааны болон сүнслэг адислалуудын тухай бодоод үз, тэгээд дараа нь бидний энэ цаг үед зохистой амьдрах өөрсдийн үүрэг хариуцлагын талаар анхааралтай эрэгцүүлэн бодоод үз.

### Агуу Эрин Үе

Хүн төрөлхтөнд өгөгдсөн сайн мэдээний хамгийн агуу эрин үед бид мөнх бус байдлын үе шатанд дэлхийд ирсэн бөгөөд үүний ихэнхийг нь бид хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Бошиглогч Иосеф Смитээс өөрийн дуртай ишлэлийг би энд татъя: “Сионыг байгуулах нь эрин зуун болгонд Бурханы хүмүүсийн сонирхлыг татдаг учир үндэслэл юм; энэ бол бошиглогчид, санваартнууд хийгээд хаад онцгой баяртайгаар авч үздэг сэдэв юм; тэд бидний амьдарч байгаа үеийг баяр баясгалантайгаар хүсэн хүлээж байв; тэгээд тэнгэрлэг хийгээд баяр баясгалантай зөн билгээр бадран, тэд бидний амьдарч байгаа манай энэ үеийн тухай дуулж, бичин бас бошиглосоор ирсэн юм, . . . бид бол Хожмын үеийн алдар сууг тохиолгон авчрахаар Бурханы [сонгосон] таалалт хүмүүс билээ.”<sup>2</sup>

1894 онд Вилфорд Вудраффын хийсэн үүнтэй адил нотолгоог авч үзэж болох юм. Ерөнхийлөгч Вудраффт тохиолдсон хүнд хэцүү бэрхшээлүүдийн тухай би та нарт сануулах хэрэггүй байх. Тэр жилүүдэд энд Нэгдсэн Улсын Өрнөд хэсэгт миний дүрсэлсэн Миссурид байсантай адил байдлаар мөн л юм бүхэн нь айдас түгшүүртэй байсан гэж би боддог. “Бүхэл улс үндэстэн” манай хүмүүсийн эсрэг эргэж, Сүмтэй дайн хийхээр бэлтгэж байсанд, хөл хорионд тусгаарлагдсан бошиглогчид, шоронд байсан төлөөлөгчид айж түгшиж (Ерөнхийлөгч Вудраффын өөрийнх нь үгээр) байлаа.<sup>3</sup>

Гэсэн хэдий ч, ийм гай зовлонгуудын дунд Ерөнхийлөгч Вудрафф хэлэхдээ: “Бүхнийг Чадагч энэ хүмүүстэй хамт байна. Хэрэв бид үүргээ биелүүлж, Бурханы зарлигуудыг сахих юм бол, бидэнд хэрэгтэй бүх илчлэлтүүдийг бид хүлээн авах болно. . . . Би . . . амьд байгаа цагтаа үүргээ биелүүлэхийг хүсч байна. Хожмын Үеийн Гэгээнтнүүд үүргээ биелүүлэхийг би хүсч байна. . . . Тэдний үүрэг агуу хийгээд хүчирхэг

юм. Бурханы мэлмий түүнчлэн бүх ариун бошиглогчид биднийг харж байна. Энэ бол бүр дэлхийн эхлэлээс хойш яригдсаар байгаа агуу эрин үе юм. Бид Бурханы хүч болон зарлигаар . . . хамтдаа цуглаад байна. Бид Бурханы ажлыг хийж байна. . . . Үүрэг зорилгоо биелүүлжээ.”<sup>4</sup>

Эцэст нь, манай өнөөгийн бэрхшээлт үед эдүгээ биднийг удирдаж байгаа өнөө үеийн бошиглогч Ерөнхийлөгч Хинклигээс иш татахыг надад зөвшөөрнө үү. Өнгөрсөн Дөрөвдүгээр сарын чуулган дээр Ерөнхийлөгч Вудраффыг доргиосон яг энэ сэдвийг тэр иш татаж бид бүгдэд хандан хэлэхдээ:

“Энэ үеийнхэн бид бол өмнө нь гарсан бүхний эцсийн ургац юм. Зөвхөн энэ Сүмийн гишүүн гэдгээ мэдэгдэх нь хангалтгүй юм. Бидэнд нэгэн эрхэм үүрэг бий. Энэ үүрэгтэйгээ нүүр учран тулж, үүн дээрээ ажиллацгаая.

“Бид хүн бүгдэд энэрлээр хандан, мууг сайнаар хариулан, Их Эзэний замуудыг үлгэр жишээгээр зааж, бидэнд зориулж Түүний төлөвлөсөн хязгааргүй олон үйлчлэлийг гүйцэлдүүлэн, Есүс Христийн үнэн дагалдагчид болж амьдрах ёстой.

“Өнгөрсөн үеийн бүхий л аюул осол дундуур бидэнд хүрч ирсэн гэрэл, ойлголт хийгээд мөнхийн үнэнүүдийн алдар суут индаументэд бид зохистойгоор амьдарцгаая. Ямар боловч, дэлхий дээр амьдарч байсан бүх хүмүүсийн дотроос энэ хосгүй өвөрмөц, гайхамшигт цаг үед бид урагш гарч ирсэн билээ. Талархалтай бай, мөн бүхнээс илүүгээр итгэлтэй бай.”<sup>5</sup>

Эдгээр 3 ишлэлд манай бошиглогчид өөрсдийнхөө амьдарч байсан цаг үеийн төлөөлөгчдийн хувиар тухайн үеийн аллагад, түүнчлэн бид бүгдийн амьдарч байгаа хожмын өдрүүдийн аюултай зүйлүүдэд анхаарал төвлөрүүлээгүй нь миний хувьд сонирхолтой хэдий ч, тэд боломж хийгээд адислалын тухай, тэрчлэн бүхнээс илүүгээр үүрэг хариуцлагын тухай, бүх эрин үеүдээс хамгийн агуу нь болох энэ эрин үед бидэнд ноогдсон онцгой боломжуудын тухай ярихыг чухалчилдаг байжээ. Эртний бошиглогчид, санваартнууд хийгээд хаад “тэнгэрлэг хийгээд баяр баясгалантай зөн билгээр бадран, бидний амьдарч байгаа манай энэ үеийн тухай тэд дуулж, бичиж бас бошиглосоор ирсэн юм” гэж хэлсэн Бошиглогч Иосефф Смитийн мөрүүдэд би дуртай. Тэд юуны тухайд тийм баяр баясгалантай байсан юм бэ? Тэд аллага, эмгэнэлт хэрэг явдал дээр анхаарал төвлөрүүлээгүй гэдэгт би та нарыг итгүүлж чадна. Вудрафф Ахын үгс гэвэл: “Бурханы мэлмий түүнчлэн бүх ариун бошиглогчид

биднийг харж байна. Энэ бол бүр дэлхийн эхлэлээс хойш яригдсаар байгаа агуу эрин үе юм.”<sup>6</sup> Ерөнхийлөгч Хинклийн үгсийг давтахыг надад зөвшөөрнө үү: “. . . өнгөрсөн үеийн бүхий л аюул осол дундуур . . . ямар боловч, дэлхий дээр амьдарч байсан бүх хүмүүсийн дотроос энэ хосгүй өвөрмөц, гайхамшигт цаг үед бид урагш гарч ирсэн билээ. Талархалтай бай, мөн бүхнээс илүүгээр итгэлтэй бай.”

Бидний амьдарч байгаа цаг үеийн тухай чухал биш аливаа гэнэтийн айдас түгшүүр намайг орхиж, би даруухан болж сүнслэг байдлын хувьд сэтгэл догдлом байж, бидэнд өгөгдсөн тэрхүү боломжоор жигүүрлэхэд энэ бүхэн та нарыг хэрхэн хүргэдгийг би мэдэхгүй юм. Бурхан Өөрийнхөө дэлхийг, Өөрийнхөө Сүмийг бас Өөрийн удирдагчдыг дээрээс харж байдаг, тэрчлэн Тэрбээр та нарыг бас харж байдаг нь тодорхой. Бид ердөө л “зүрх сэтгэлдээ цэвэр ариун” байхад мөн бид итгэлтэй байхад анхаарцгаая. Та нар хичнээн их адислагдах билээ. Та нарын хүүхдүүд ач зээ нар хичнээн азтай байх билээ.

Энэ тухай бодоод үз. Сайн мэдээний эрин зуунуудаас доошхи эртний хүмүүс—түүний дотор бидний эцэг эхчүүд олон тохиолдолд—та нарт болон надад өгөгдсөн тэрхүү адислалуудтай ойролцоо адислалуудыг хаана ч хүлээн авч байгаагүй юм.

Харанхуйлагдсан дэлхийд сайн мэдээний гэрлийг хүргэхэд бидэнд үзүүлсэн тэрхүү тусламжийн тухай бодоод үз. Бидэнд ойролцоогоор бараг 55,000 номлогч байгаа нь—энэ цаг үе эхэлснээс хойш дэлхийн түүхийн бусад ямар ч эрин зуунд, бусад ямар ч цаг үеийнхээс хамаагүй илүү тоо юм гэдэг нь тов тодорхой байна. Мөн энэ тоо өөрсдийнхөө өмнөх хүмүүсийг орлохоор ирдэг номлогчдоор хоёр жил тутам давтан сэлбэгдэж байдаг билээ! Гэвч бүр илүү олон номлогчид бидэнд хэрэгтэй байна. Бид 170 орчим оронд Хожмын Үеийн Гэгээнтэн гишүүд, номлогчид, номлолын албатай байна. Бид судруудаа 100 гаруй хэл дээр хэвлэдэг.

Эртний дэлхийд 6,000 гаруй жилийн өмнө нэг ариун сүм (энэ нь хоёр юм уу гурван удаа дахин баригдсан боловч Иерусалим дахь Мориа Уулан дээрх тэр ариун сүм байжээ) мөн Мормоны Номны түүхэнд хоёр буюу гурван ариун сүм байжээ, гэтэл эдүгээ бид тоог нь тогтоож чадахааргүй тийм их хурднаар ариун сүмүүд олширч байгаа үед амьдарч байна. Хэдэн минутын өмнө бид үйл ажиллагаа явуулж байгаа 119 ариун сүмтэй байлаа, мөн илүү олныг барихаар зарлах буюу одоо барьж байгаа гэдэгт би бат итгэж байна.

Манай гэр бүлийн түүхүүдийг баримтжуулах болон бидний нас барагсдыг гэтэлгэх аврагч ёслолуудыг системтэйгээр гүйцэтгэхэд компьютерийн гайхамшигийг нэмээд үз. Тэргүүн Зөвлөл, Арванхоёр болон бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг дэлхий даяар зөөж бүх газрын бүх Гэгээнтнүүдэд Их Эзэний тухай гэрчлэлээ биечлэн хэлэх боломж олгож байгаа орчин үеийн тээврийг дээр нь нэм. Эдүгээ бид явж очиж чадахгүй газартаа судруудад өгүүлдэгчлэн, бид хиймэл дагуулын шууд нэвтрүүлгүүдээр өнөө оройных шиг бид “илгээж” чаддаг (С ба Г 84:62–ыг үз).

Боловсрол, шинжлэх ухаан, технологи, холбоо харилцаа, тээвэр, анагаах ухаан, шимт гэжээлийн бүх элементүүдийг болон биднийг хүрээлэгч илчлэлтийг үүн дээр нэм, ингэвэл, эцсийн өдрүүдэд Бурхан Өөрийн сүнсийг “бүх маханбодь” дээр юүлэх болно, мөн бүхэл дэлхий, бүх хүн төрөлхтөн Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн нэг хэсэг болсон хүч чармайлтын бүх талбарт ирэх гэрлээр адислагдах болно гэж тэнгэр элч Моронай Хуучин Гэрээний бошиглогч Иоелоос иш татан бошиглогч хөвгүүн Иосеф Смитэд дахин давтан хэлсэн тэр зүйл ямар утга учиртайг бид танин мэдэх болно. (Иоел 2:28; налуу бичлэг нэмэгдсэн болно; мөн Иосеф Смит—Түүх 1:41–ийг үз).

Манай эрин үед бидэнд байгаа бүх адислалуудыг бид анхаарч үзээд Тэнгэр дэх Эцэгтээ “Та Хичнээн Агуу Билээ,”<sup>7</sup> “Та Хичнээн Сайхан Билээ” гэж хэлэхийн тулд бид зогсдог билээ.

Чухамдаа бол, Бошиглогч Иосеф Смит, Ерөнхийлөгч Вудрафф, Ерөнхийлөгч Хинкли нарын өгүүлсэн тэдгээр удирдагчид, гэр бүлүүд хийгээд тэдгээрт амьдардаг хүмүүсийн тухай үзэл бодол надад байдаг. Тэдний тухай, тэдгээр эрт үеүдийн тухай түүнчлэн тэдэнд тулгарч байсан сүйрүүлэгч нөхцөл байдлуудын тухай би олонтаа бодож үзсэн. Тэдэнд аймшигтай хүнд цаг үе тулгарч байсан, өөрсдийнхөө эрин үеүдэд тэд ихэнхдээ амжилт олдоггүй байсан. Урвалт болон харанхуй нь түүхэн дэх эртний эрин үе болгонд заавал ирдэг байлаа. Чухамдаа бол, эдгээр хожмын өдрүүд дэх сайн мэдээний Сэргээлтийн бүхэл үзэл баримтлал нь хүмүүний түүхийн эрт дээр үед байх боломжгүй байсан бөгөөд тиймээс энэхүү эцсийн ялгуусан эрин үед хэрэгжсэн билээ.

Абрахамын үр удамд учирч байсан бэрхшээлүүдийг (одоо ч хэвээр байгаа) бид мэднэ. Египетийг орхин гарсан Израилын хүмүүст тулгарч байсан Мосегийн асуудлууд Египетийн нөлөөнөөс (нүглүүдээс) гарахад нь тэдэнд тусалж чадаагүй юм. Исаиа бол Израилын

арван овог умардад алдагдахыг харсан бошиглогч байлаа. Иеремиа, Езекиел болон Даниел нар бүгдээрээ Израилын боолчлолын үеийн бошиглогчид байв. Шинэ Гэрээний агуу хүмүүс Петр, Иаков, Иохан, Паул нар бүр Аврагчийг дэлхийгээс явахаас өмнө, мэдээж хэрэг тэднийг амьд сэрүүн ахуйд тэр үеийн дэлхийд урвалт толгойгоо өндийлгөж эхэлснийг бүгдээрээ харсан билээ. Тэдэнд тулгарч байсан хүнд зовлон зүдгүүрийн тухай, хайрладаг улс үндэстэн нь ялзрал, аллага, эмх замбараагүй явдалд унаж байгаа тухай Мормон, Моронай хоёрын хоорондох зүрх шимшрүүлэм харилцаагаар төгсөж буй эрин үед амьдарч байсан Мормоны Номны бошиглогчдын тухай бодоод үз л дээ.

Товчхондоо, аль нэг төрлийн урвалт хийгээд устгал нь цагийн уртад бидэнд дээрээс уламжлан ирсэн ерөнхий эрин үе болгонд эцсийн хувь тавилан нь болж иржээ. Гэвч би өөрийн онол үзлийг хэлье. Тэд өөрсдөө амжилт олно гэдгийг мэдэж байсны улмаас биш харин та нар амжилт олно гэдгийг мэдэж байсан учраас өнгөрсөн эрин зуунууд дахь агуу эрэгтэйчүүд, агуу эмэгтэйчүүд үргэлж урагшилж, гэрчилсээр, чадах бүхнээ хийхийг хичээсээр ирсэн гэдэг нь миний онол үзэл билээ. Тэд эр зориг, найдварыг олж авч байсан нь өөрсдийнхөө нөхцөл байдлуудаас ихэнхдээ биш, харин өнөөдөр дэлхий даяар цуглаад байгаа хэдэн зуун мянган залуу насанд хүрэгчид та нарын адил—ийм гайхамшигт цугларагсдаас, сайн мэдээ ялгууснаар ялан дийлэхийг харахын төлөөх шийдвэр төгс хүчин чармайлтаас олж авч байсан гэдэгт би итгэдэг.

Эцсийн өдрүүдэд түүний цэдгийг хүлээн авах бидэнд хандан Моронай нэгэнтээ хэлэхдээ:

“Болгоогтун, та нарын дунд эдгээр зүйлс гарч ирэх тэр өдөр, удахгүй ирэх ёстой түүний талаар Их Эзэн надад агуу их хийгээд гайхамшигт зүйлүүдийг үзүүлсэн болой.

“Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч, та нар өмнө минь буй мэтээр би та нартай ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ” (Мормон 8:34–35) гэжээ.

Аль нэг арга замаар бошиглогчид бүгдээрээ түүнчлэн эртний төлөөлөгчид манай өнөө үеийн тодорхой агшингуудыг—нүдээрээ харсан гэдэгт мөн амжилт нэн багатай байсан тэдний эрин үеүдэд энэ нь тэднийг зоригжуулдаг байсан гэж би үнэнээсээ боддог. Эрт дээр үеийн тэдгээр ах нар бид гайхмаар олон болохыг мэддэг байжээ. Мосе, Нифай, Жаредын ах зэрэг бошиглогчид хожмын өдрүүдийг

маш их нарийвчлалтай үзэгдэлд харсан байна. Тэдний харсан зүйлээс зарим нь баярлууштай биш байсан хэдий ч, тэдгээр эрт дээр үеийнхэн эцсийн эцэст үл унах нэгэн эрин үе байх болно гэдгийг мэдсэнээр зориг ордог байжээ.

Тэдний үе биш харин бидний үе тэдэнд “тэнгэрлэг хийгээд баяр баясгалантай хүсэн хүлээлтийг” өгч ялалтын тухай дуулж, бошиглоход тэднийг хүргэдэг байжээ. Манай үе бол цагийн эхлэлээс бошиглогчид хамтаараа ярьж, хүсэн хүлээсээр ирсэн, мөн эрт дээр үеийн ах нар маань сүнсний дэлхийд биднийг дэмжин урамшуулж байсан ажээ. Өөрсдөө бүрэн амжилттай байхыг харах тэдний боломж нэн бодит арга замаар бидний итгэлтэй байдал мөн бидний ялалтаас хамаарч байлаа. Алма хийгээд Абинадайг төлөөлөн, тэдний гуйж байсан зүйлийн төлөө, Петр хийгээд Паулыг, түүнчлэн тэдний хийсэн золиослоуудыг нүгэл ба хилэнцийн эсрэг эцсийн өдрүүдийн сүнслэг тулалдаанд орох санаанд би дуртай. Хэрэв та нар түүхийн тавцан дээрх үүргийн ийм төрөлд сэтгэл догдолж эс чадах аваас, та нар сэтгэл догдолж ерөөсөө чадахгүй!

## Хуримын Найр

Эрин үеийн тухай энэхүү үзэл бодол дээр үүнийг аяндаа дагалдан гарах өөр нэг элементийг нэмэхийг надад зөвшөөрнө үү. Манай үе бол бүх эрин үеүдээс сүүлчийнх бөгөөд хамгийн агуу нь учраас, бүх зүйл эцсийн эцэст манай эрин үед оргилдоо хүрч гүйцэлдэх учраас, чухам иймээс, эрт дээр үеийн Сүмийн гишүүдийн мөрөн дээр, одоогийн биднийхтэй адил арга замаар хэрэгжүүлэх боломжгүй байсан тийм нэг өвөрмөц үүрэг хариуцлага Сүмд өнөө үед бидэн дээр тохоогдоод байна. Абрахамын буюу Мосегийн, Исаиагийн буюу Езекиелийн, тэр ч байтугай Шинэ Гэрээний үе дэх Иаков, Иохан нарын үеийн Сүмтэй адилгүй нь, Бурханы Хургыг —өөрийнх нь биеэр, ялгуусан алдар суунд, Түүний мянган жилд Эздийн Их Эзэн, Хаадын Хааны үүргээр нь хүлээн авахын тулд *Бурханы Хурганы Сүмийг бэлтгэх үүрэг бидэнд ноогдож байна*. Өөр ямар ч эрин үед энэхүү үүрэг ноогдож байгаагүй.

Судрын хэлээр бол бид бүх түүхэн дэх хүргэн Хүүгийн ирэлтэд бэрийг бэлтгэх болон хуримын найранд уригдахуйц зохистой байх үүрэг хариуцлага ноогдсон хүмүүс юм. (Матай 25:1–12; 22:2–14; С ба Г 88:92, 96). Энэ бүгдийг нийлүүлж хэлбэл—энэ нь бидний амьдралын туршид ч байна уу, бидний хүүхдүүдийн эсвэл бидний ач зээ нарын үед ч байна уу ялгаагүй—бид энэхүү үүрэг хариуцлагыг Сүмийн

хувьд, бас хувь хүмүүсийн хувьд хамтаараа биелүүлэхийн тулд, Христийг бидэн дээр ирүүлэхийн тулд зохистой байж, Түүнийг бидэнтэй мэндлэхэд, Тэрээр биднийг хүлээн зөвшөөрч, хүлээн авч, биднийг тэврэн золгохдоо зохистой байхын төлөө хэзээ ч сулруулах ёсгүй. Тэрхүү эрхэм ариун цаг үед Түүнд бидний танилцуулах амьдрал Түүнд тохирохуйц зохистой байх ёстой!

## Бид Түүнд Хүлээн Авагдахуйц Байх Ёстой

Тиймээс ирээдүйн төлөөх айдас буюу бөмбөгдөлтөөс хоргодох байрны хэмжээний талаар санаа зовж, би айдсаар дүүрлээ хэмээн, бошиглогдсон тэрхүү өнө удаан хугацааны тухайд, эрх мэдлийг шилжүүлэх тухайд, энэ бол Түүний Сүм болохыг Түүнд Өөрт нь бид танилцуулах тэр цаг хугацааны тухайд амьдралаа бэлтгэх (мөн Сүмийн гишүүдийг амьдралаа бэлтгэхэд би тусалж чадах ) үүрэг хариуцлага нь дааж давагдашгүй мэт болсон мэдрэмжийг хойш тавь.

Христийг ирэхэд, хэрэв бид Түүний хувьд хүлээн авч болохуйц байх юм бол Түүний Сүмийн гишүүд ямар байвал зохих ёстой, Түүний Сүмийн гишүүд тийм л байдалтай харагдаж, тийм л байдалтай ажилладаг байх ёстойг би мэднэ. Бид Түүний ажлыг хийж Түүний заадаг зүйлүүдээр амьдарч байх ёстой. Бид үнэхээр Түүний шавь нар байсныг Тэрээр хурдан таних ёстой. Ерөнхийлөгч Ж. Рюбен Бага Кларк нэгэнтээ зөвлөхдөө, бидний итгэл ялган танихад хэцүү байх ёсгүй гэжээ.<sup>8</sup>

Тийм ээ, эцсийн тэрхүү агуу цагт, хэрэв бид, бид итгэгчид байна гэж хэлэхээсээ илүүгээр бид үүнийг үзүүлэх нь дээр байх нь дамжиггүй. Хоньчин Өөрийнхөө хонийг таньдаг бөгөөд тэрхүү агуу өдөр бид Түүний дагалдагчид гэдэг нь үйл хэргээр ч, үг хэлээр ч танигдаж байх ёстой.

Чухам иймээс л Ерөнхийлөгч Хинкли: “Зүгээр л энэ Сүмийн гишүүн байна гэдэг нь [бидний хувьд, та нар болон миний хувьд, эдүгээ манай үед] хангалтгүй юм. . . . Бид Христийн . . . үнэн дагалдагчдын хувиар амьдрах ёстой”<sup>9</sup> хэмээн хэлсэн нь лавтай.

Тийм ээ, хайрт залуу анд нар минь, энэ бол хожмын өдрүүд, мөн та нар бас би хамгийн шилдэг Хожмын Үеийн Гэгээнтнүүд байх ёстой. Энэхүү сүүлчийн үгэнд онцгой анхаарах учиртай юм шүү.

Энэ бүхэн хэзээ дуусах вэ? Христ ялгуусан байдлаар бүх нийтэд харагдсан тэр үед Мянган Жил эхлэх үү? Би мэдэхгүй гэдгээ та нарт аль хэдийн хэлсэн шүү дээ. Миний мэдэж байгаа юм гэвэл эхлэлтийн үе нь 184 жилийн өмнө Ариун Ойн Цоорхойд болсон үйл

явдал мөн. Анхны Үзэгдлийн үр дүнг болон дараа нь түүнийг дагалдсан зүйлийг, бид урьд хожид үзэгдээгүй адислалуудын үед, Хүргэн хүү эцэст нь ялгуусан байдлаар хүрч ирэн тэр биднийг өөрөө хуримын найрандаа зүй ёсоор урихуйцаар итгэлтэй хийгээд цэвэр ариунаар амьдрах зорилгын төлөөнөө—бидэнд өгөгдсөн тэрхүү адислалуудын үед бид амьдарч байгааг би мэднэ.

Энэхүү хожмын өдрүүдэд та нарт бас та нарын үр удамд аз жаргалтай ирээдүй бий юу? Бүр илүү их итгэлтэйгээр хэлбэл та нарт сайн сайхан ирээдүй бий. Бүх хуримын найр баяртай үйл явдлууд байдаг. Хожмын үеийн муу совинт сэрэмжлүүлгүүд болон бошиглолууд гүйцэлдэхэд хэцүү цаг үе ирэх үү? Мэдээж хэрэг ирэх болно. Цаг ямагт ирдэг шүү дээ. Бэлтгэлтэй байгтун. Христийн агуу хадан дээр барьдаг хүмүүс шуурга, мөндөр, хуй салхины хүчит эргүүлгийг тэсч гарах уу? Тэд тэсэн гарна гэдгийг та нар мэдэж байгаа. Үүнийг та нар сайн үгээр мэднэ. Үүнийг та нар Түүний үгээр мэднэ! “Хадан дээр та нар сууриа тавьж. . . тэр бат бөх суурь бол, дээр нь хэрэв эрэгтэйчүүд [мөн эмэгтэйчүүд] баригдвал тэд унахгүй суурь болой” (Хиламан 5:12-ыг үз).

Хайрт залуу ах, эгч нар минь, би та нарт хайраа үлдээе, мөн Бурхан зөвхөн амьдардаг төдийгүй Тэр бас бидэнд хайртай, Тэр та нарт хайртай гэдэг гэрчлэлээ би та нарт үлдээе. Түүний хийдэг юм болгон бидний сайн сайхны төлөө бас бидний хамгаалалтын төлөө байдаг. Хилэнц уй гашуу дэлхийд байдаг хэдий ч, Түүний дотор хилэнц буюу хортой муу юм байдаггүй. Тэр бол бидний Эцэг,— төгс төгөлдөр эцэг—бөгөөд Тэр биднийг шуурганаас хамгаалах болно.

Есүс бол Христ, Бурханы Ариун бөгөөд Төрсөн Ганц Хүү гэдгийг төдийгүй бас Тэрээр амьдардаг, Тэрээр бидэнд хайртай, Түүний цагаатгагч хүч чадал хийгээд ач гавьяагаар бид бас мөнхөд амьдрах болно гэдгийг би гэрчилж байна. Тэрээр үхлийг мөн тамыг бидний төлөө байлдан дагуулсан юм, хэрэв бид Түүнийг итгэлтэйгээр дагах юм бол, бас Тэрээр айдсыг мөн тийм арга замаар байлдан дагуулах болно.

Энэ бол дэлхий дээрх Бурханы Сүм болоод хаант улс. Иосеф Смит бошиглогч байсан бөгөөд Гордон Б. Хинкли бол бошиглогч. Үнэн сэргээгдсэн юм. Энэ бүх мэдлэг хийгээд энэ бүх аюулгүй байдал бидний хувьд боломжтой болсон цаг үед та бид төрснөөрөө азтай юм.

Та бүгд итгэл, өөдрөг үзлээр, өөрийгөө зориулан амьдрахын төлөөнөө та нарын хүн нэг бүрд хувьчлан

би төлөөлөгчийн адислалыг үлдээж байна. Амьдралын бэрхшээлүүдийн тухайд айх буюу гуньж гутрах биш, харин буурь суурьтай байхын төлөө би та нарыг адисалж байна. Хожмын өдрүүд дэх Гэгээнтнүүдийн баяр баясгаланг мэдэрч, хэзээ ч айж түгшүүрлэх буюу санаагаар доройтон унахгүй байхын төлөө би та нарыг адисалж байна. Үүний оронд та нарын бодох учиртай ганцхан санаа зоволт бол—энэхүү агуу эрин үеийн бүх адислалууд бидний хүн бүрийн дээр мөн амьдралд нь бидний нөлөөлдөг хүмүүс дээр юүлэгдэж болохын тулд бид хэрхэн илүү бүрэн дүүрэн, илүү итгэлтэйгээр амьдарч болох вэ? гэдгийг бодох тухай ихэд хувийн шинжтэй хүсэлт юм.

“Бүү ай, бяцхан сүрэг. . . . Санаа бодол болгондоо [Христ рүү] хар; бүү эргэлз, бүү ай.” “Хичнээн агуу адислалуудыг Эцэг гаргаа байлгаж . . . та нарын төлөө бэлтгэснийг та нар хараахан ойлгоогүй байгаа билээ. . . . Сайхан хөгжил хөөртэй бай. . . . Хаант улс та нарынх болой, мөн үүн дээрх адислалууд та нарынх билээ, мөн үүрд мөнхийн баялгууд та нарынх билээ” (С ба Г 6:34, 36; 78:17–18).

Өөрийн адислал, өөрийн хайр, мөн эдгээр юмсын бүрэн байдлын тухай төлөөлөгчийн гэрчлэлийг би Их Эзэн Есүс Христийн хамгаалагч нэрээр та нарт үлдээж байна, амен.

### Тэмдэглэл

1. “Faith in Every Footstep,” *Ensign*, 1997 оны Нэгдүгээр сар, 15.
2. *History of the Church*, 4:609–610
3. Wilford Woodruff’s diary, 1889 оны 12-р сарын 31, Жеймс Б. Аллен, Глен М. Леопард, *The Story of the Latter-day Saints*, 2 дахь хэвлэлээс иш татав (1992), 420.
4. James R. Clark, түүвэр зохиол, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть. (1965–75), 3:258; мөн Gordon B. Hinckley, Conference Report, 2004 оны 4-р сар, 84–85; эсвэл *Ensign*, 2004 оны 5-р сар, 83-ыг үз.
5. Conference Report, 2004 оны 4-р сар, 85; эсвэл *Ensign*, 2004 оны 5-р сар, 84.
6. Conference Report, 2004 оны 4-р сар, 85; налуу бичлэг нэмэв.
7. “How Great Thou Art,” *Hymns*, дугаар 86; налуу бичлэг нэмэв.
8. *The Charted Course of the Church in Education*, хянан засварласан хэвлэл (1994), 3–7.
9. Conference Report, 2004 оны 4-р сар, 85; эсвэл *Ensign*, 2004 оны 5-р сар, 84.